**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,**
**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2014 оны 04 сарын 21 өдөр    Дугаар 128    Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын хуралдааны 2012 оны 67 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Хөдөө, орон нутагт интернэтийн үнийг бууруулах талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Ажлын хэсгийн тайлан, үр дүнг газрын удирдлагад энэ оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг /Ф.Ганбаатар/-т даалгасугай.

ДАРГА    Ц.ЖАДАМБАА

111457

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын даргын 2014 оны 04 сарын 21. өдрийн
128. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

УХА0514 5202965

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

| | |
|---|---|
| Ф.Ганбаатар | Тус газрын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга |

Ажлын хэсгийн нарийн бичиг:

| | |
|---|---|
| Ц.Одхүү | Тус газрын харилцаа холбоо, дэвшилтэт технологийн ажлын албаны мэргэжилтэн |

Ажлын хэсгийн гишүүд:

| | |
|---|---|
| Б.Мягмарнаран | Тус газрын шинэчлэлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга |
| Д.Батбаяр | Тус газрын төсөл, хөтөлбөрийн хэлтсийн дарга |
| Б.Буян-Өлзий | Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн дарга |
| П.Маргад-Эрдэнэ | Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ийн гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/ |
| Ч.Золбаяр | Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ийн бодлого төлөвлөлтийн газрын дарга /тохиролцсоноор/ |
| Б.Тэрбиш | Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ийн санхүү, бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга /тохиролцсоноор/ |

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2014 оны 04 сарын 21 өдрийн 128 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Зорилго:

Тус газарт засгийн газрын хуралдааны 2012 оны 67 дугаар тэмдэглэлийн дагуу хөдөө, орон нутагт интернэтийн үнийг 3 дахин бууруулж хурдыг 2 дахин нэмэх талаар үүрэг өгсний дагуу судалгаа хийж, дүгнэлт гаргана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Ажлын хэсэг нь дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Хот ба орон нутгийн хэрэглэгчдийн авч буйинтернэтийн хэрэглээний үнийн талаар судалгаа хийнэ.
2. Хөдөө, орон нутагт интернэтийн үнийг бууруулах талаар хийх шаталсан арга хэмжээнүүдийг тодорхойлно.
3. Хийгдсэн судалгаа, нөхцөл байдал дээр тулгуурлан дүгнэлт гаргана.

Хугацаа:

2014 оны 4 сарын 22-ноос 2014 оны 6 –р сарын 15

Хүрэх үр дүн:

Хөдөө, орон нутагт интернэтийн үнийг бууруулахад цаашид ямар арга хэмжээ хэрэгжүүлэх талаар нэгдсэн дүгнэлтийг боловсруулна.